

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ОРШИЛ	3
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
2.1. Төслийн нэр	4
2.2. Төсөл хэрэгжүүлэгч	4
2.3. Төслийн байршил	4
2.4. Уурхайн нөөц	5
2.5. Хүчин чадал.....	5
2.6. Уурхайн ажлын горим	5
2.7. Уулын ажлын календарь төлөвлөлт	6
2.8. Ашиглалтын систем	6
2.9. Уурхайн тоног төхөөрөмжийн сонголт	6
2.10. Хөрсний овоолго	7
2.11. Уурхайн тэсэлгээ.....	7
2.12. Бутлан-ангилах хэсгийн технологийн горим	7
2.13. Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо.....	8
2.14. Ажилчдын бүтэц бүрэлдэхүүн, удирдлага зохион байгуулалт.....	8
2.15. Төслийн дэд бүтэц.....	9
БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	10
БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ ..	13
БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	15
БҮЛЭГ 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
6.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	17
6.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	19
6.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	19
6.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	20
6.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20
6.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	21
6.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
6.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	23
6.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	25
6.10. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө	26
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ	27
ДҮГНЭЛТ	28

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ..... 29

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	4
Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбицол	4
Хүснэгт 3. Тоног төхөөрөмжийн жагсаалт.....	6
Хүснэгт 4. Уурхайд ажиллах тоног төхөөрөмжүүд.....	6
Хүснэгт 5. Тэсэлгээний ажлын тооцоо	7
Хүснэгт 6. Төслийн нийт ажилчдын тоо	8
Хүснэгт 7. Барилга, байгууламжийн мэдээлэл.....	9
Хүснэгт 8. Төслийн нийт усны хэрэглээ.....	9
Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	17
Хүснэгт 10. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	19
Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	19
Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	21
Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	23
Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	25
Хүснэгт 16. Олон нийгэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө	26
Хүснэгт 17. 2024 оны БОМТ-нд зарцуулах нийт зардал.....	27

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны ордын байршлын зураг	5
Зураг 2. Барилгын чулуу бутлан-ангилах хэсгийн технологийн схем	8

БҮЛЭГ 1. ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны орд төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

БОМТ-ний тайлан боловсруулах аргачлал:

Тус төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Сүх-Индэр” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар		0711006136
3	Уурхайн нэр “Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны орд ашиглах төсөл		
4	Ордын	Нийслэл/Хот/ Аймаг	Дорнод аймаг
5	байршил	Сум/Дүүрэг	Хэрлэн
6	Ашигт малтмалын төрөл		Барилгын чулуу
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		ДО-004А
8	Аж ахуйн	Аймаг/Хот	Дорнод аймаг
9	нэгжийн	Сум/Дүүрэг	Хэрлэн
10	хаяг	Баг/Хороо	1-р баг
11	Захирлын	Нэр	Захирал Э. Энхболд
12	хаяг	Гар утас	976-99992068

2.1. Төслийн нэр

“Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны ордыг ашиглах төсөл

2.2. Төсөл хэрэгжүүлэгч


“Сүх-Индэр” ХХК

2.3. Төслийн байршил

“Зүүн-Өлзийт” барилгын чулууны орд нь Дорнод аймгийн төв болох Чойбалсан хотоос зүүн тийш 18 км-т, Хэрлэнгийн зүүн гүүрнээс 15 км-т Хэрлэн голын урд талд байрладаг. Уурхайн талбай нь Улаанбаатар хотоос зүүн зүгт 658 км зайд байрлана. Нийт 25.9 га талбайтай.

Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбицол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	114	40	59.60	48	05	57.10
2	114	40	59.60	48	06	15.60
3	114	41	21.50	48	06	15.60
4	114	41	21.50	48	05	57.10



Зураг 1. “Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны ордын байршлын зураг

2.4. Уурхайн нөөц

“Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны ордод эрэл үнэлгээ, хайгуулын ажлыг явуулж улмаар 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдөр нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнгийн тайланг Уул Уурхайн Яам, Ашигт Малтмалын Газрын Тосны Газрын дэргэдэх Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн бодитой (В) зэрэглэлээр 3,008,942.5 м³ буюу 7,432,088.0 тн, боломжтой (С) зэрэглэлээр 2,367,224.8 м³ буюу 5,847,045.3 тн, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 5,376,167.3 м³ буюу 13,279,133.3 тн барилгын чулууны нөөцийг Улсын нөөцийн бүртгэлд бүртгүүлсэн байна.

2.5. Хүчин чадал

Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт орших “Сүх-Индэр” ХХК-ийн “Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны ордыг 82 жилийн хугацаанд ашиглах бөгөөд жилд 36.0 мян.м³ барилгын чулуу олборлох ба бутлан ангилах хэсэгт сийрэгжүүлснээр 50.4 мян.м³ барилгын чулуу боловсруулах хүчин чадалтай.

2.6. Уурхайн ажлын горим

Уурхайн үйл ажиллагаа нь 4 сараас 9 сарыг дуустал тасралтгүй ажиллагаатай явагдах бөгөөд Монгол улсын хууль тогтоомжуудад заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд,

цаг агаарын хүндрэл, засвар үйлчилгээ зэрэг хүчин зүйлүүдийг тооцсон. Хоногт 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг байна. Жилд 110 хоног ажиллана.

2.7. Уулын ажлын календарь төлөвлөлт

“Зүүн-Өлзийт” нэртэй Барилгын чулууны орд нь жилд 36.0 мян.м³/жил дайрга олборлох хүчин чадалтай байна. Уурхайн ашиглалтын 5 жилийн хугацаанд нийт 147.49 мян.м³ хөрс хуулж, 1325.97 мян.тн дайрга олборлоно. Хөрс хуулалтын дундаж коэффициент 0.11 м³/тн байна.

2.8. Ашиглалтын систем

Ордыг ил аргаар нээж, ашиглах бөгөөд тэсэлгээтэй, авто тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглана.

2.9. Уурхайн тоног төхөөрөмжийн сонголт

Хүснэгт 3. Тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Төхөөрөмжийн нэр	Марк	Бүтээмж, тн/цаг	Ш/тоо	Хөдөлгүүрийн чадал, кВт
1	Чичиргээт тэжээгүүр	ZSW320x90	50-120	1	7.5
2	Хацарт бутлуур-1	PE500x750	40-110	1	45
3	Алхат бутлуур	PF1210	80-120	1	110
4	Чичиргээт шигшүүр	ЗҮК1237	30-180	1	11
5	Туузан конвейер	BW900*8m		1	11
6	Туузан конвейер	BW900*11.5m		1	11
7	Туузан конвейер	BW1050*9m		1	11
8	Туузан конвейер	BW750*16m		1	11
9	Туузан конвейер	BW750*16m		1	11
10	Туузан конвейер	BW750*16m		1	11
11	Гоос баригч төхөөрөмж	DMC-32		2	1.5

Хүснэгт 4. Уурхайд ажиллах тоног төхөөрөмжүүд

Тоног төхөөрөмийн төрөл	Марк	Ш/тоо
Үндсэн тоног төхөөрөмж		
Утгурт ачигч	Long Yu ZL 935	1
Экскаватор	CAT330	1
Автосамосвал	Howo	2
Туслах тоног төхөөрөмж		
Суудлын машин	Pick up	1
Зам услагч	Foton	1
Түлшний машин	Hyundai	1
Микро автобус	Hyundao istana	1
Ачааны машин	Hyundai Mighty	1

2.10. Хөрсний овоолго

Шимт хөрсийг Long Yu ZL935 маркийн утгуурт ачигчаар хуулна. Шимт хөрсийг ил уурхай, бутлан ангилах хэсгийн талбай, уурхайн гадаад тээврийн замын талбай, хөрсний овоолгын суурийн талбайгаас 0.2 метрийн зузаантайгаар хуулна. Нийтдээ эхний 5 жил цулаар 3,148.0 м³ буюу сийрэгжсэнээр 3.777.6 м³ шимт хөрс хуулж овоолно.

2.11. Уурхайн тэсэлгээ


“Зүүн-Өлзийт” нэртэй Барилгын чулууны ордын жилд хуулах уулын цулын хэмжээ бага учир тэсэлгээг жилд нэг удаа хийнэ.

Хүснэгт 5. Тэсэлгээний ажлын тооцоо

№	Т.тэмдэг	Үзүүлэлт	Х.нэгж	Утга	
1	бш	Чулуулгийн бат бөхийн хязгаар	Шахалт	МПа	72.0
	бши		Шилжрэлт	МПа	15.3
	бс		Суналт	МПа	13.1
2	Ү	Чулуулгийн нягт	т/м ³	т/м3	
3	қж	Тэсрэх бодисын жишиг хувийн зарцуулалт	г/м ³	г/м3	
4	Ктб	Тэсрэх бодисын жиших коэффициент	-	1.13	
5	Кдб	Чулуулгийн бутлагдлын зэргийг тооцох коэффициент	-	1.57	
6	Кца	Чулуулгийн цавшлыг тооцох коэффициент	-	1.2	
7	Кбө	Цэнэгийн бөөгнөрлийг тооцох коэффициент	-	0.9	
8	Киг	Тэсрэлтэнд өртөх чөлөөт ил гадаргын тоог тооцох коэффициент	-	5.5	
9	Кэз	Тэсрэлтэнд өртөх чулуулгийн эзлэхүүнийг тооцох коэффициент	-	1.2	
10	қт	Тэсрэх бодисын тооцооны хувийн зарцуулалт	г/м ³	628	

2.12. Бутлан-ангилах хэсгийн технологийн горим

Ил уурхайн олборлолтын үед үүсэх уулын чулуулгийн хамгийн том ширхэглэлийн хэмжээг -400 мм-ээр тооцсон. Ил уурхайгаас ирсэн чулуулгийг чичиргээт тэжээгүүрээр эхний шатны хацарт бутлуурт өгнө. Хацарт бутлуураар бутлагдсан бүтээгдэхүүнийг 2 дахь шатны алхан бутлуурт өгнө. 2 дахь шатны алхан бутлуураас гарсан бүтээгдэхүүнийг чичиргээт шигшүүрийн тэжээл болгон өгнө. Чичиргээт шигшүүрээс -5+0 мм, -10+5 мм, -20+10 мм, +20 мм ширхэглэлтэй 4 ангиллын бүтээгдэхүүн гарах бөгөөд +20 ширхэглэлтэй бүтээгдэхүүн эргэлтийн ачааллаар 2 дахь шатны алхан бутлуурт өгөгдөнө.



Зураг 2. Барилгын чулуу бутлан-ангилах хэсгийн технологийн схем

2.13. Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо

Ширхэглэлээр ангилсан барилгын чулууг зах зээл дээр нийлүүлэхийн тулд технологийн туршилт болон лабораторийн шинжилгээнд үндэслэн -5+0 мм (16.07%), -10+5 мм (50.46%), -20+10 мм (33.46%) ширхэглэлтэй барилгын чулууг гаргахаар тооцоолсон байна.

2.14. Ажилчдын бүтэц бүрэлдэхүүн, удирдлага зохион байгуулалт

Хүснэгт 6. Төслийн нийт ажилчдын тоо

№	Хэсэг нэгж	Ажилчдын орон тоо
1	Төв оффис	3
2	Уулын хэсэг	7
3	Бутлан ангилах хэсэг	2
4	Засвар механикийн хэсэг	2
5	Аж ахуй, үйлчилгээний хэсэг	4
	Нийт	18

2.15.Төслийн дэд бүтэц

Барилга байгууламж:

Хүснэгт 7. Барилга, байгууламжийн мэдээлэл

№	Барилгын нэр	Х.нэгж	Хэмжээ	Тайлбар
1	Уурхайн манаач	м ²	12	1 ш зөөврийн сууц
2	Засварын агуулах	м ²	28.4	40 тн контейнер 1 ш
3	Цайны газар	м ²	28.4	40 тн тохиж.контейнер 1 ш
4	Засварын талбай	м ²	80	Талбайн үржил шимт хөрсийг хуулж, хайрга асгаж бэлдэнэ

Цахилгаан хангамж:

“Дорнод аймгийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 6 кВ-ийн агаарын шугамаас 400 кВт-ын хүчин чадалтай дэд станц угсарч ЦЭХ-ээр хангана.

Усан хангамж:

“Сүх-Индэр” ХХК нь унд ахуйн усны хэрэгцээ болон зам усалгаагаа өөрийн эзэмшлийн гүний худгаас хангана.

Унд ахуйн хэрэглээнд хэрэглэх усны хэмжээ. Уурхайн хотхоны унд-ахуйн усны хэрэглээнд жилд 39.6 м³ 82 жилийн хугацаанд 3247.2 м³ ус хэрэглэхээр байна.

Зам усалгаанд ашиглагдах усны хэмжээ. Зам усалгаанд жилд 748.8 м³ нийт 82 жилийн хугацаанд 61,401.6 м³ ус ашиглахаар байна.

Хүснэгт 8. Төслийн нийт усны хэрэглээ

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Нийт ашиглалтын жилд
1	Унд, ахуйн усны хэрэгцээ	м ³	3,247.0
2	Зам талбайн усалгаа	м ³	61,401.6
	Нийт усны хэрэгцээ	м ³	64,648.6

БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Физик газарзүй:

Физик газарзүйн мужлалаар Хангайн муж Сэлэнгэ Орхоны савын дундаж өндөр уулс хэсэгт харьяалагдана. Засаг захиргааны хуваариар Дорнод аймгийн Хэрлэн сумын 5-р багийн нутагт харьяалагдах бөгөөд аймгийн төвөөс 2.5 км зайтай.

Газарзүйн байрлал, газрын гадарга:

Төслийн талбай нь жижиг толгодорхог рельефтэй Хэрлэн голоо дагасан дунд зэргийн уулархаг толгодорхог гадаргуутай. Тэдгээрийн харьцангуй өндөр нь 25-100 м хооронд хэлбэлзэх бөгөөд хажуу налуугийн өнцөг нь 5-10 градусаас ихгүй. Тэдгээрийн хооронд томоохон хэмжээний тэгшивтэр гадаргуутай талархаг рельефийг үүсгэсэн байна. Үнэмлэхүй өндөр нь 800 м-ээс өндөргүй.

Байгаль газарзүйн хувьд дорнод монголын өргөн уудам тал нутагт далайн төвшнөөс дээш 600-700 метр өргөгдсөн тал хээрийн бүсэд багтдаг.

Газрын гадарга нь 745-750 м орчим өргөгдсөн өндөрлөг тэгш тал, Хэрлэн голын хаяа татмын хэсгийг хамран байрших ба ямар нэгэн нам уул, толгод байхгүй юм. Газрын гадаргын хэлбэр дүрсийн хувьд ерөнхийдөө тэгш тал газрын шинжтэй, талын аажуу урсгалтай, өргөн голдрилтой талын голын хэв шинж бүхий Хэрлэн голын татам бүхий тэгш, үл мэдэг хотос, хонхор газар голлоно.

Цаг агаар:

Жилийн хамгийн хүйтэн сар нь 1 дүгээр сар буюу дундаж агаарын температур нь -23.4°C , хамгийн дулаан сар нь 7 дугаар сар буюу дундаж агаарын температур нь $+22.1^{\circ}\text{C}$ байдаг байна.

Жилийн дундаж температур нутгийн хойд болон зүүн хэсгээр 0°C – -2°C , төв ба өмнөд хэсгээр 0°C – $+2^{\circ}\text{C}$ үзүүлэлттэй байна. Жилийн хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж температур ихэнх нутгаар -20°C , халх голын сав дагуу -25°C бол хамгийн их хүйтэн нь халх голд -47°C хүрсэн байна. харин хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж температур 20°C , хамгийн их халуун 41°C хүрчээ. Тус нутгаар 5°C хавар 4 дүгээр сарын 14-нөөс 5 дугаар сарын 1-ны хооронд дайран дулаарч намар 9 дүгээр сарын 27-ноос 10 дугаар сарын 13-ны хооронд дайран хүйтэрч нийтдээ 149-182 хоног 5°C - аас дулаан үе үргэлжилдэг байна. Жилд нар гийгүүлэх хугацаа хойд хэсгээр 2700-аас бага цаг, төв ба зүүн хэсгээр 2700-3000 цаг, өмнөд хэсгээр 3000-3200 цаг, зуны нэг өдөр 9-10 цаг, өвлийн нэг өдөр 5-6 цаг байна.

Усан орчин:

Монгол орны дорнод бүс нутаг нь ус зүйн сүлжээний хувьд Номхон далайн ба Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамрагдана. Голууд нь Хэнтийн нуруу, Их Хянганы уулсаас эх аван Дорнодын тал нутгийг зөвхөн дайран гарч урсдаг бөгөөд тал нутгаар урсахдаа томоохон цутгал голуудыг өөртөө нэгтгэн авах нь ховор, харин усаа ууршуулж ямар нэг хэмжээгээр алддаг байна. Энд нуур нилээд өргөн тархсан байх боловч жижиг хэмжээний нуур зонхилно. Нуурууд нь ихэвчлэн гадагш урсгалгүй байх ба талархаг газрын хотос хонхорт тогтсон байна. Зарим нуурууд гандуу хуурай үед ширгэж хужир, шал тойром болдог.

Дорнод аймгийн нутгаар хэрлэн, халх, улз, дэгээ, нөмрөг, гал, дөч, ямалхай зэрэг гол мөрд, буйр, хөх, яхь нуур болон бусад олон арван жижиг нуур устай. Эмчилгээ сувилгааны ач холбогдол бүхий улсын болон аймаг орон нутгийн зэрэглэлтэй утаат минчүүр, хөх нүдэн, ар булаг, тамсаг булаг, шувуут зэрэг 10 гаруй рашаан, жирмийн цагаан, хулстайн тосон, булан шавар зэрэг 10 орчим эмчилгээний шавартай эрдэст нууруудтай. Эдгээр нь бүгд “нүүрсхүчлийн хүйтэн” рашааны мужид багтдаг. Гол мөрний үндсэн тэжээл нь зуны хур бороо, гүний ус үлдсэн хэсгийг бүрдүүлдэг. Гол мөрөн, нуурын мөсний горим нь намар 11-р сарын сүүлчээр хөлдөж, хавар 4-р сарын дундуур гэсдэг байна.

Судалгааны талбайн Гидрографын нөхцөл нь Хэрлэн гол ба түүний цутгалангуудаар тэжээгдэх бөгөөд Чойбалсан хотын урдуур урсаж өнгөрдөг. Судалгааны талбайн дундуур өргөрөгийн дагуу урсан өнгөрнө. Голын өргөн 80-100м гүн нь 1,5-2м, урсгалын хурд нь 0,4-0,85м/секундын хооронд хэлбэлзэнэ. ан сүлжээ харьцангуй сайн хөгжсөн бүс нутагт багтана. Ордын дүүргээр Туул, Бүхэг, Түргэн зэрэг байнгын урсгалтай голууд урсан өнгөрдөг бөгөөд эдгээр голуудын гольдролын өргөн нь 30-70 м, гүн нь 0.5-1.5 м, урсгалын хурд дунджаар 1.0-1.6 м/сек гэж өмнөх судлаачид тогтоосон байна.

Төслийн талбайн хэмжээнд хэмжээнд хэрэглээний усны хэрэгцээг өөрийн эзэмшлийн гүний худгаас зөөврөөр хангана.

Хөрс:

Дорнод аймгийн Хэрлэн сум болон Хэрлэн голын орчмын бүс нутаг нь хөрс-газарзүйн мужлалаар Төв Азийн хөрс-био уур амьсгалын их мужийн Хангайн мужийн Хотгорын бүсшилийн хэв шинж бүхий Баянтүмэнгийн 17-р тойрогт багтана. Баянтүмэнгийн 17-р тойргийн хувьд ухаа толгод бүхий нутгаар сайргархаг, карбонатлаг хар хүрэн, тэгш тал газраар карбонатлаг хүрэн шороон, нам дор хотос болон чийгэрхэг газруудаар нугархаг хүрэн хөрсний хэв шинж зонхилон тархах бол Хэрлэн голын татмын системд аллювийн нугат-намгийн болон аллювийн ширэгт хөрсний шинж тархсан шинжтэй. Төсөл хэрэгжих талбайд талбайн гадаргын хэлбэр дүрстэй уялдан, хүрэн шороон хөрс болон аллювын ширэгт хөрсний хэв шинж тархсан байна.

Ургамал:

Монгол орны ургамал газарзүйн мужлалтаар Евроазийн шилмүүст ой, нуга хээрийн их мужийн, Дорнод Азийн мужийн Дэгээ-Нөмрөгийн тойрог, Евроазийн хээрийн их мужийн, Дорнод Азийн мужийн Улз-Хэрлэнгийн тойрог, Халх голын тойрог, Төв Азийн мужийн, Матад-Тамсагийн тойрогт тус тус хамаарна.

Төсөл хэрэгжих талбай нь ургамлын хувьд Дорнод Монголын хээрийн тойрогт хамаарна. Дорнод Монголын тал ухаа толгод бүхий харьцангуй өндөрлөг тэгш тал нутагт хамрагдах ба хуурай хээрийн ургамалшилийн хэв шинж зонхилдог.

Төслийн талбайд Хиаг улалжит, үетэн алаг өвст, бударгана алаг өвстэй дэрс бүхий нугын ургамлын бүлгэмдэл зонхилно.

Энэ нутагт бутлаг үетэнт хуурай хээрийн ландшафт зонхилно. Чулуусаг алаг өвс ботуульт бүлгэмдэлтэй, хосолсон чулуусаг алаг өвс хялганат *stipa krylovii*, *arenaria capilaris*, *acrtogeron gramimeneum*, *Artemisia ruthifolia*, *caryopter is Mongolica* зарим газраа *achnatherum splendens*, *carex duriuscula*, *iris lacteal*, *carex enervis*, нутгийн өмнөд хэсгээр Монголын Дорнод хэв шинж, харгана бүхий жижиг бутлаг үетэнт хиаг-харганат, хиагт бүлгэмдэлтэй *Leymuschinensis*, *stipa Krylovii*, *saagana microphilia*. Вонголын хээрийн бусад хээрээс ялгагдах онцлог нь хэд хэдэн зүйлийн харгана, агь зэрэг хуурайсаг сөөг, сөөгөнцөр ургамал элбэг тархдагт оршино (Н.Өлзийхутаг, 1995 он).

Амьтан:

Төсөл хэрэгжиж буй нутаг нь газарзүйн мужлалаар Монгол дагуурын тойрогт хамаарна. Төсөл хэрэгжих бүс нутагт дагуур зараа, брандтын багваахай, сахалт багваахай, дагуур огдой, монгол огдой, бор туулай, дагуур зурам, орог зусаг, хээрийн хулгана, саарал чоно, шар үнэг, хярс, цагаан зээр зэрэг амьтад тохиолдоно.

Нийгэм эдийн засгийн үзүүлэлт:

Монгол улсын шинэ Үндсэн хуулинд Монгол улсын Засаг захиргааны нэгж аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо байна гэж заасны дагуу 1994 оны 7 дугаар сарын 1-ны өдөр Чойбалсан хот нь Хэрлэн сум болон зохион байгуулагджээ. Чойбалсан хот нь нийслэл Улаанбаатар хотоос 655 км, Хэнтий аймгийн Чингис хотоос 334 км, Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотоос 200 км зайд оршдог. Хойд талаараа Адуунчулууны нүүрсний уурхай, урд талаараа Хэрлэн гол, баруун, зүүн талаараа жижиг гүвээ толгодоор хүрээлэгдсэн 28,0 мян га талбай бүхий нутагтай, уртаашаа 20 км сунаж тогтсон Монгол улсын том зэрэглэлд ордог хот юм. Чойбалсан хот нь Дорнод аймгийн төв бөгөөд Хэрлэн сум нь 10 багтай, 13.2 мянган өрх, 46.2 мянган хүн амтай, нийт хүн амын 48 хувь нь төвлөрсөн хангамжтай орон сууцанд амьдардаг. Эдийн засгийн хувьд төвийн бүсэд багтдаг бөгөөд аж үйлдвэрийн салбар, дэд бүтэц сайн хөгжсөн бүс нутагт харъяалагдана. Хэрлэн сум нь Дорнод аймгийн нийт төсвийн орологын 48.1%-г (2020 оны байдлаар) бүрдүүлсэн нь аймагтаа нэгт орж байна.

БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн талбай нь Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт байрлах “Сүх-Индэр” ХХК нь ДО-004А тоот тусгай зөвшөөрөл бүхий 25.9 га талбайтай. Барилгын чулууны орд”-ыг ил аргаар ашиглах төсөл хэрэгжүүлнэ.

Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Уурхайн үйл ажиллагааны үед газрын хэвлий эвдэгдэх,
- Уурхайн үйл ажиллагаагаар газрын гадарга өөрчлөгдөх,
- Уурхайн үйл ажиллагааг ТЭЗҮ төлөвлөлтийн талаар явуулахгүй байх.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн тоосжилт үүсэх,
- Бутлуурын хэсэгт тоосжилт үүсэх,
- Уурхайн тэсэлгээ хийх үед дуу чимээний нөлөөлөл үүсэх,
- Тээврийн хэрэгслийн яндангаас үүсэх хорт хий утаа, тортог үүсэх,
- Хог хаягдлаас үүсэх орчны эвгүй үнэр үүсэх.

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Технологийн болон унд ахуйн усыг гүний худгийн усаар хангана. Энэ тохиолдолд газрын гадаргын болон гүний усны нөөцөд тодорхой хэмжээний хомсдол үүсгэх болно.
- Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал хөрсийг бохирдуулснаас гадаргын болон гүний усанд шууд бусаар нөлөөлнө.
- Технологийн процесс, тоосжилтыг дарахад ашиглах болон ундны усыг гүний худгаас хангах учир гүний усны нөөцөд бага хэмжээний өөрчлөлт оруулна.
- Түлш шатахуун, шатах тослох материалууд, бохир ус алдагдсанаас үүдэн бага гүнд орших уст давхарга бохирдох.
- Газрын доорх усан орчин бохирдсон тохиолдолд тэр нь хөрсөөр дамжин хүрээгээ тэлж хөрс, хүн, мал амьтан, ургамалд сөргөөр шууд нөлөөлнө.

Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс олон салаа зам үүсч хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх,
- Хөрсний шинж чанар техноген гаралтай хүчин зүйлүүдийн нөлөөгөөр элэгдэлд өртөж, хими-физик шинж чанар нь алдагдсанаар хөрс хуурайших, хөрсний биологийн нөөц хомсдох, үржил шим нь алдагдах,
- Тээвэрлэлтийн машин техникт үзлэг засвар хийх үед нефтийн бүтээгдэхүүн, шатах, тослох материал, хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулах.
- Хөрс хуулах, карьерын талбайгаар хөрс сулран ургамлын нөмрөг бүр мөсөн устаж үгүй болно.
- Ажилчдын суурингийн эргэн тойрон, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн улмаар тоног төхөөрөөмжийг газрын гадарга дээр засварлах, тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөн зэргээс хөрс талхлагдан, ургамлын төрөл зүйл, ургалт доройтно.

- Олборлолтын үеийн шороо тоос орчны ургамалжилтанд нөлөөлж, ургалт удааширна.

Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Олборлолтын талбайд ямар нэгэн шавжийн бүлгэмдэл, хөхтөн амьтад байхгүй. Олборлолт хийж байгаа газарт болон хаягдал овоолох талбайд байршиж байгаа шавж идэштэн, мэрэгч амьтдын нүх оромж, орчинтойгоо устаж үгүйрнэ,
- Дуу шуугиан, машин техник болон хүний хөл хөдөлгөөн ихсэх зэргээс улбаалан, ан амьтад, шувууд үргэн дайжиж, тархалт байршилт нь өөрчлөгдөнө,
- Уурхайн ухсан нүх суваг, шуудуу руу мал амьтан уурхайн талбай руу унаж, бэртэх аюултай.

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:

- Уурхайн үйл ажиллагааны явцад техникийн бүрэн бүтэн байдал алдагдах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүйгээс эсвэл гэнэтийн аюул осол гарснаас улбаалан ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх зэрэг сөрөг нөлөөлөл үүсэх магадлалтай,
- Уурхайн ажлын үед ашиглаж буй техник, машин механизмаас дуу чимээ, тоосжилт ихэссэнээс хүн ам, ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлнэ,
- Уул уурхайн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлийн дуу чимээ, тоосжилт ихэссэнээр хүн ам болон ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлнэ.
- Уурхайд ажиллагсдыг хортой, хүнд нөхцөлд ажилладаг учир эрүүл мэндэд эрсдэл учрах аюултай.

БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“СҮХ-ИНДЭР” ХХК-ийн “Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөө оршино.

“Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны ордыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан.

Энэхүү БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах гол сөрөг нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж түүнд шаардагдах хөрөнгө зардлыг тусгадаг.

“Сүх-Индэр” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ны дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 5,270.0 мян.төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Хуулин дээрх шаардлагын дагуу “Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны ордын үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсрууллаа.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго нь “Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны ордын үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

БҮЛЭГ 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төгрөг, / 2024 он /	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар									
1	-Ил уурхайн олборлолтын үед тоосжилт үүсэх, -Бутлуурын үед үүсэх тоосжилт, -Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт, -Тэсэлгээний үед үүсэх тоосжилт.	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмол хийх, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах, хүнд машин механизмуудыг техникийн үзлэгт оруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх	Тээврийн хэрэгсэл	-	50,000	4	200,000	Жил бүр	-Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS 4585:2007. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 3384:1982. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, -MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга.
2		Уурхайн тээвэрлэлтийн зам, уурхай орчимд тоосжилт дарах усалгааг тогтмол хийх	Уурхайн талбай, тээвэрлэлтийн зам	-	-	-	Дотоод төлөвлөлт-өөр	Тогтмол	
3		Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслүүдийн төлбөрийг төлнө.	Тээврийн хэрэгсэл	-	-	-	Дотоод төлөвлөлт-өөр	Жил бүр	
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч									
1	-Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс	Уурхайн талбайн эргэн тойронд уурхайн үйл ажиллагаа явагдаж байгааг анхааруулсан тэмдэг	Уурхайн талбайд	-	-	-	100,000	Уурхайн үйл ажиллагааны үед	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага,

2	хөрс элэгдэл эвдрэлд өртөх, -Хог хаягдлаас үүдэн орчин бохирдох, -ШТМ асгарч газрын гадарга хөрсийг бохирдуулах.	тэмдэглэгээг нэмэгдүүлэх, сайжруулах. Өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах, нөхөн сэргээлтэнд ашиглах.	Шимт хөрсний овоолго	-	-	-	Дотоод төлөвлөлт- өөр	2024 онд	- MNS 3310-91, Хөрс. Хөрснийагрохимийн үзүүлэлтийг тодорхойлох, - MNS 17.5.1.19-92, БОХ. Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах шаардлага, - MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”
3		Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавьж ажиллах, шатах тослох материал алдагдсан тохиолдолд цаг тухай бүрт нь саармагжуулах арга хэмжээ авах	ШТМ	-	-	-	-	Тухай бүрт	
4		Шатах тослох материалыг хадгалах талбайг хатуу хучилттай болгох, цементлэх.	ШТМ-ын талбай	-	-	-	Дотоод төлөвлөлт- өөр	2024 онд	
Усан орчин									
1	-Бохир усыг ил задгай асгаснаас үүдэн орчны бохирдол үүсэх.	Ахуйн бохир усыг ил задгай асгахгүй байх		-	-	-	-	Тухай бүрт	-Усны тухай хууль, -MNS 900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт.
Амьтан									
1	Цахилгаан дамжуулах шугамд шувуу саатах, бэртэж, үхэх.	Компаний эзэмшилд байгаа цахилгаан дамжуулах агаарын шугамд шувуу үргээгч хийж байрлуулах.	Шувуу үргээгч	ш	-	-	Дотоод төлөвлөлт- өөр	2024 онд	-Амьтны тухай хууль
Нийт зардал							300,000		

6.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 10. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээх хамгаалах арга хэмжээ	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг / 2024 он /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Нөхөн сэргээлт хийх.	Хаягдал чулуугаар уурхайн хуучин ухсан байсан газруудад нөхөн дүүргэлт хийх.	0.3 га талбайд	-	-	2,000,000	2024 онд	- MNS 5916:2008, Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт - MNS 5917:2008, Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
Нийт зардал						2,000,000		

6.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх газрыг Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас санал авсны үндсэн дээр эвдэрсэн газрыг техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхээр санал, шийдвэрт хүрсэн.

Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг / 2024 он /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутагтай хамтарч	Орон нутгаас санал авсны үндсэн дээр Хэрлэн сумын 5-р багийн нутаг дэвсгэрт шугам ухаж авсны улмаас эвдэрч,	0.075 га газарт 3 м гүнтэй 2,250 м ³ газрыг булж, тэгшилж,	-	-	2,000,000	2024 онд	-Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх хэрэгжүүлэх гарын авлага,

	ажиллах, дүйцүүлэн хамгаалах ажил хийх санал орон нутгаас авах, хэрэгжүүлэх.	хоосон орон зай үүссэн байгаа газарт нөхөн сэргээлт хийх ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх.	техникийн нөхөн сэргээлт хийнэ.					-БОНБНУ-ий тухай хууль.
2		5-р багийн нутагт шугам ухаж авсны улмаас эвдэрч, хоосон орон зай үүсэж орхигдсон газарт техникийн нөхөн сэргээлтийг 3 жилийн хугацаанд гүйцэтгэж байгаа бөгөөд энэхүү ажлыг 2024 онд дуусгаж, орон нутагт хүлээлгэн өгч акт үйлдэнэ.	3 жилийн хугацаанд нийт 1.25 га газарт бүхий 37,500 м3 газарт техникийн нөхөн сэргээлт хийсэн					
3	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих	2024 онд тарьсан бургасыг арчлан хамгаалах, услаж тордох.	-	-	-	300,000	2024 онд	
Нийт зардал						2,300,000		

6.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн эдэлбэр газар болон түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ хийгдэхгүй болно.

6.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвор илрээгүй. Уурхайн үйл ажиллагааны явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олоход үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

6.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг / 2024 он /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	-Болзошгүй аюул, осол, аваар гарах. -Галын гэнэтийн аюул үүсэх, -Ажилчид бэртэх, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх. -Уурхайд тэсэлгээний үед аюул үүсэх.	Мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Ажилчдад	-	-	300,000	Жил бүр	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17) -MNS6010-2009 Гамшгийн холбогдолтой нэр томъёо, тодорхойлолт, ерөнхий анги, -MNS 5002 2000: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй -MNS 12.4. 005 – 1985: Хөдөлмөр хамгаалал.Шуугианаас хамгаалах хэрэгсэл ба аргууд.
2		Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажиллуулах	Уурхайн ажилчид	18	-	Үйл ажиллагааны зардалд орсон	Жил бүр	
3		Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, багаж хэрэгслийг нэмэгдүүлэх, сайжруулах	Уурхайн кемп орчимд	-	-	Үйл ажиллагааны зардалд орсон	2024 онд	
4		Ажилд гарахын өмнө ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Уурхайн удирдлага	-	-	-	Тогтмол	
5		Аваар, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Уурхайн удирдлага	-	-	Дотоод төлөвлөлтөөр	Жил бүр	
6		Тэсэлгээг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх.	Тэсэлгээ	-	-	Дотоод төлөвлөлтөөр	2024 онд	
7		Уурхайн тэсэлгээний үед аюулгүй ажиллагааг сайтар мөрдөж ажиллах, мэргэжлийн тэсэлгээчнээр гүйцэтгүүлэх.		-	-	-	2024 онд	
Нийт зардал						300,000		

6.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг /2024 он/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хатуу хог хаягдал	“Чойбалсан хөгжил” ОНӨҮГ-тэй хог тээвэрлэлтийн гэрээг шинэчлэн байгуулж, хог хаягдлыг тухай бүрт тээвэрлүүлэх.	Хог хаягдал	-	100,000	-	100,000	Жилд 1 удаа	-Хог хаягдлын тухай хууль /2017.05.12/, -MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага, -Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль.
2		Хог хаягдлын төвлөрсөн түр цэгийг суурийг хөрсөнд нэвчихээргүй хатуу хучилттай болгох, цементлэх.	Хог хаягдлын цэг	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр	2024 онд	
3	Аюултай хог хаягдал	Ашигласан шатах, тослох материалыг зориулалтын саванд хадгалах, уурхайн орчинд асгарч алдагдахаас тухай бүр сэргийлэх, ШТМ дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлүүлэх	ШТМ хадгалах сав, поошик дүүрэхээр тээвэрлүүлэх.	ш	100,000	1	100,000	Тухай бүрт	
4		ШТМ болон аюултай хог хаягдлыг хадгалах талбайг хатуу хучилттай болгох	ШТМ хадгалах талбай	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр	2024 онд	
5		Тэсэлгээний үед хэрэглэсэн тэсрэх бодисын сав баглаа боодлын хаягдлыг тэсэлгээний мэргэжлийн байгууллага хариуцаж, буцаан авч явж устгуулах.	Тэсрэх бодисын сав баглаа боодлын хаягдал	-	-	-	-	2024 онд	
Нийт зардал							200,000		

6.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны ордыг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүрт илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэнэ.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож тусгана.

Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгж зардал, төг	Нийт зардал, төг / 2024 он /	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
Агаарын орчин							
1	Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээ хийлгэх	-Ил уурхай орчмоос, -Бутлуурын хэсгээс.	Жилд 1 удаа	Агаарын сорьц дээж 30,000	60,000	Дорнод аймгийн цаг уур орчны шинжилгээний харьяа лабораторит	-MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, -MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга,
Хөрсөн бүрхэвч							
1	Агрохимийн шинжилгээ: Хөрсний химийн үзүүлэлт (pH, EC _{2.5} dS/m, P ₂ O ₅ , K ₂ O, CaCO ₃)	-Ил уурхай орчмоос, -Кемп орчмоос.	Жилд 1 удаа	25,000	50,000	Итгэмжлэгдсэн хөрсний шинжилгээний лаборатори	-MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, -MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага
2	Хөрсний хүнд металлын шинжилгээ: (Cr, Cd, Pb, Ni, Co, Cu)	-Тээвэрлэлтийн замаас.	Жилд 1 удаа	27,000	27,000		-MNS ISO 11047:2001 Хөрсний чанар.

							Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох.
Усан орчин							
1	Усны химийн ерөнхий шинжилгээ: (рН, ЕС, TDS) нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ (CaCO ₃)	Унд ахуйн уснаас	Жилд 1 удаа	33,000	33,000	Усны итгэмжлэгдсэн лаборатори	-MNS 3935:1986. Ундны ус хяналт шинжилгээнд тавих ерөнхий шаардлага, - MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус- химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх, -MNS4432:1997 Ундны ус. Өнгийг тодорхойлох арга,
Нийт зардал					170,000		

6.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон Төсөв / 2024 он /	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 онд				
			6-р сар	7-р сар	8-р сар		
1	Ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Үйл ажиллагааны зардалд орсон		+		Уурхайн удирдлага	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж байх шаардлагатай.
2	Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээг шинэчлэн байгуулж, гэрээний дагуу хамтран ажиллах, шинэчлэх	Дотоод төлөвлөлтөөр	+	+	+	Уурхайн удирдлага	Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан нягт хамтран ажиллах
3	Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх.	Мэргэжлийн байгууллагатай тохиролцох.		+		Уурхайн удирдлага	Байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэж байх шаардлагатай.
Нийт зардал		-					

6.10. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө

"Сүх-Индэр" ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ.

Хүснэгт 16. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд		Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Зохион байгуулах газар
Дорнод аймаг	Орон нутгийн байгаль орчны газар	Тайлан хэлбэрээр, уурхайн талбайд очих.	БОМТ-ийн 2024 оны хэрэгжилтийн тайлан	11-р сарын 01-ны өдрийн дотор	Уурхайд
БОАЖЯ	БОАЖЯ-ны ХБОБНУГ	Тайлан			БОАЖЯ-ны ХБОБНУГ-т
Төрийн захиргааны төв байгууллага	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга	Тайлан, төлөвлөгөөг тайлан хэлбэрээр	2024 оны БОМТ	12-р сарын 01-ны өдрийн дотор	-

2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

“Сүх-Индэр” ХХК-ийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

2024 онд БОМТ-нд нийт **5,270,000** сая.төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 17. 2024 оны БОМТ-нд зарцуулах нийт зардал

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2024 он /төгрөг/
1	Байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	300,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	2,000,000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	2,300,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	200,000
7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	300,000
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
9	Олон нийтэд тайлагнах төлөвлөгөө	-
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	170,000
Нийт дүн		5,270,000

ДҮГНЭЛТ

Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт орших “Сүх-Индэр” ХХК-ийн “Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу биелэлтийн тайланг боловсруулж дараах дүгнэлтэд хүрлээ.

“СҮХ-ИНДЭР” ХХК-ийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайланг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Уг төслийн явцад байгаль экологийн унаган төрхийг хамгаалахын тулд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүн, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэргийг мөрдлөг болгон ажиллаж, 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль орчны арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

“Зүүн-Өлзийт” барилгын чулууны ордын БОМТ-нд 2024 онд нийт **5,270,000** төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

“СҮХ-ИНДЭР” ХХК нь БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх үүрэгтэй.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
5. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” БОАЖСайдын А/618 тоот тушаал, 2019 он.
6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал 2014
7. Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт орших ДО-004А тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Зүүн-Өлзийт” Барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ, 2021 он
8. Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт орших “Зүүн-Өлзийт” Барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2022 он
9. Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт орших “Зүүн-Өлзийт” Барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах төслийн БОМТ, 2023 он
10. <http://www.legalinfo.mn//>